

МОНОС ХҮНС ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 09 дүгээр
сарын 09-ний өдөр

№ 04

Улаанбаатар
хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
Гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, 77 дугаар зүйлийн 77.1, 77.4 дэх заалт, Компанийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.8 дахь заалт болон Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн ШИЙДВЭРЛЭХ НЬ:

- Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнд:
 - Лувсангийн Хүрэлбаатар
 - Хүрэлбаатарын Ананд
 - Чимэддоржийн Баттогтох
 - Агваандоржийн Отгондарь
 - Хүрэлбаатарын Солонго
 - Цэдэндамбын Цэцэгбадам нарыг улируулан сонгож,
- Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүнд:
 - Ганболдын Золжаргал
 - Мянганбуугийн Сарандаваа
 - Данзанбалжирын Энхжаргал
 - Дашийн Гэрэлт-Од
 - Нанжидын Улаанхүү нарыг тус тус сонгосугай.
- Компанийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж, “Монос хүнс” ХК-ийн дүрэм, “Төлөөлөн удирдах зөвлөлийн журам” зэрэг засаглалын тогтолцооны холбогдох эрх зүйн баримт бичгийг мөрдөж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нийт гишүүдэд үүрэг болгосугай.
- Шинээр томилогдсон ердийн болон хараат бус гишүүдийн мэдээллийг хувьцаа эзэмшигчид, Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Биржид хууль журамд заасны дагуу мэдэгдэхийг Гүйцэтгэх захирал /А.Отгондарь/-д үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН

ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ДАРГА

Х.АНАНД



МОНОС ХҮНС ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 09 дүгээр
сарын 09-ний өдөр

№ 05

Улаанбаатар
хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2024 оны төсөвт тодотгол хийх тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, Компанийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.6 дахь заалт болон Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн ШИЙДВЭРЛЭХ НЬ:

- Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх хороодын тоо болон гишүүдийн тоо нэмэгдсэнтэй холбоотой 2024 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 02 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан ТУЗ-ийн 2024 оны төсөвт энэхүү тогтоолын Хавсралт №01-д заасны дагуу тодотгол өөрчлөлт оруулан баталсугай.
- Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны төсөвт хяналт тавьж, тайлагнаж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Цалин урамшуулал хорооны даргад даалгасугай.
- Энэхүү тогтоол батлагдсантай холбоотой 2024 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 02 тоот тогтоол, түүний хавсралтыг хүчингүй болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ДАРГА


Х.АНАНД

МОНОС ХҮНС ХК ТУЗ-ИЙН 2024 ОНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ
/тодотгосон/

| | /мянган төгрөг/ |
|---|-----------------|
| 1. ТУЗ-ийн хурлын зардал | 12,000 |
| • ТУЗ-ийн ээлжит хурал | 8,000 |
| • ТУЗ-ийн ээлжит бус хурал | 4,000 |
| 2. ТУЗ-ийн гишүүдийн цалин, НДШ | 83,482 |
| • ТУЗ-ийн ээлжит хурал | 62,282 |
| • ТУЗ-ийн ээлжит бус хурал | 21,200 |
| 3. ТУЗ-ийн сургалтын зардал | 2,000 |
| 4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зардал | 40,000 |
| НИЙТ ДҮН | 137,482 |